



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: letter@moh.gov.mn, <http://moh.gov.mn>

2026.05.21 № 1/2427
танай 2026.04.20-ны № 19 -Т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Т.МӨНХСАЙХАН ТАНАА**

Танаас ирүүлсэн эрүүл мэндийн салбарын зардлын талаарх асуулгатай танилцаж, асуулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авна уу.

Хавсралт 14 хуудастай.

САЙД



Э.БАТШУГАР

14'250115

ЭМС-ын 2026 оны 05 дугаар
сарын 21 өдрийн 1/247 албан
бичгийн хавсралт



АСУУЛГЫН ХАРИУ

НЭГ. Монгол Улсын Засгийн газраас эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалинг 2026 онд үе шаттайгаар 75 хүртэл хувь нэмэгдүүлэх бодлогын шийдвэр гаргаж 2026 оны 1 сараас 30 хувийг нэмэгдүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Энэхүү шийдвэр нь салбарын хүний нөөцийн тогтвортой байдал, үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх стратегийн ач холбогдолтой бөгөөд эмнэлгийн тусламж, үйлчилгээ дэх албан бус төлбөрийн эрсдэлийг бууруулах, эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийн ажлын бүтээмжийг үнэлэх, мэргэжлийн үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилттой юм.

Эрүүл мэндийн салбарт нийт 67360 албан хаагч ажиллаж байгаагаас эмч 16093, сувилагч 15099 байгаа нь 1 эмчид 2 сувилагч ногдох зорилтот түвшинд хүрэхэд сувилагчийн орон тоо дутагдалтай байна. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн дутагдлыг даван туулах, мэргэжилтнүүдийн тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх нь цалин хөлсний бодлогын гол үндэслэл болж байна.

Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын тоог Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр цалин авч буй албан хаагчдын статистик мэдээн дээр үндэслэхэд нийт 36721 албан хаагч төрийн албанаас цалинжиж /ӨЭМТ-ийн албан хаагч ороогүй тоо/ байна.

Асуулт 1.1 Цалингийн нэмэгдлийн бодлогын шийдвэрийн эрх зүйн үндэс, гарсан огноо, хэрэгжүүлэх үе шат, нөхцөлийн дэлгэрэнгүй танилцуулга;

Хариулт:

Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалин, хөлсийг нэмэгдүүлэх хүрээнд Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо хоорондын “Эрүүл мэндийн салбарын 2024-2026 оны хамтын нэмэлт хэлэлцээр”-ийг эхлүүлж 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр хэлэлцэн зөвшилцөж байгуулсан болно. Уг хэлэлцээрт үндсэн цалингийн хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 30 хувиар, 2026 оны 8 дугаар сараас эхлэн сар бүр 9 хувиар нэмэгдүүлж, 2026 оны 12 дугаар сард 2024 оны Засгийн газрын 238 дугаар тогтоолтой харьцуулахад 75 хувиар нэмэгдүүлэхээр тусгасан.

Уг хэлэлцээрийн хүрээд Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газраас тогтоох заалтын дагуу Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар соёл, эрүүл мэнд, боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлэх асуудлыг хэлэлцүүлэн Засгийн газрын 224, 225 дугаар тогтоолыг тус тус баталсан. Засгийн газрын 2025 оны 224 дүгээр тогтоолоор холбогдох салбарын төсвийн ерөнхийлөн захирагч нарт 2026 оны батлагдсан төсөвтөө багтаан дээрх тогтоолуудын хэрэгжилтийг хангах үүрэг өгөгдсөний дагуу Эрүүл мэндийн сайдын

2026 оны А/11 дүгээр тушаалаар эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын ТҮЭМ, ТҮ, ТҮМ зэрэглэлийн үндсэн цалинг 30 хувиар нэмэгдүүлэн баталж хэрэгжүүлсэн. Гэвч Засгийн газрын 2025 оны 225 дугаар тогтоолоор Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын хавсралтад баталсан нэмэгдэл цалинг тооцох хувь хэмжээг өмнөх 2024 оны 238 дугаар тогтоолын дагуу хэрэгжүүлэхээр тогтоосон нь үндсэн цалингийн зөрүүтэй байдлыг бий болгож, маргааныг дагуулсан. Иймд тус асуудлыг шийдвэрлэх зорилгоор Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар нэмэгдэл “царцаасан” шийдвэрийг хүчингүй болгож, үндсэн цалинг Засгийн газрын тогтоолоор шинэчлэн батлах шийдвэр гарч 135 дугаар тогтоол батлагдсан бөгөөд 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн.

Цалин нэмэгдүүлэх эрх зүйн баримт бичиг батлуулах үйл явц нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14 дэх хэсгийн дагуу Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хариуцан Төрийн албаны зөвлөлтэй хамтран Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж шийдвэрлэсэн бөгөөд УИХ-аар Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд туссан нэмэгдсэн төсөвт багтаан хэрэгжүүлэх шийдвэрийг гаргасан байна.

Асуулт 1.2 2026 оны байдлаар уг шийдвэрийн хэрэгжилтийн явц, бодит гүйцэтгэл (хэдэн хувьд хүрсэн, нэмэгдлийг албан тушаалын ангилал, зэрэглэл)-ийн талаар мэдээлэл:

Хариулт:

2026 оны 5 дугаар сарын байдлаар эрүүл мэндийн салбарын ажилчдын үндсэн цалинг 1-4 дүгээр сард 30 хувиар нэмэгдүүлж, нэмэгдэл цалинг өмнөх түвшинд “царцаан” хэрэгжүүлсэн бол 2026 оны 05 дугаар сарын 1-ээс үндсэн цалин ЗГ-ын 2026 оны 135 дугаар тогтоолын дагуу тогтоож нэмэгдэл цалинг нэмж тогтоосон цалингаас тооцож олгож эхэлсэн.

Тоон үзүүлэлтээр эмч, сувилагч, бусад албан хаагчдын үндсэн цалин нэмэгдүүлсэн шийдвэрийг өмнөх үндсэн цалинтай харьцуулж үзвэл эмчийн (тухайлбал, ТҮЭМ-6 зэрэглэл) үндсэн цалин 2025 онд 1,559,000 төгрөг байсан бол 2026 оны 1 дүгээр сараас 2,026,700 төгрөгт хүрч 467 мянган төгрөгөөр өссөн бол сувилагчийн (ТҮЭМ-3 зэрэглэл) үндсэн цалин 1,347,000 төгрөгөөс 1,751,100 төгрөгт хүрч үндсэн цалин 404 мянган төгрөгөөр өссөн байна. /Албан тушаалын зэрэглэлээр дэлгэрэнгүй хүснэгтээр харуулав/

Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын үндсэн цалингийн өөрчлөлт

зэрэглэл	Албан тушаалын тухайн зэрэглэлд хамаарах албан тушаал	Засгийн газрын тогтоол					Хамтын хэлэлцээр (75%) 2026.12.01	Өсөлтийн хувь 2026.01.01-2026.07.31	Өсөлтийн хувь 2026.01.01-2026.12.31
		ЗГ-ын 2023 оны №241	ЗГ-ын 2024 оны №128	ЗГ-ын 2024 оны №238	ЗГ-ын 2025 оны №135				
ТҮЭМ-9	Эмнэлгийн Захирал, дарга	1,548.0	1,703.0	1,805.0	2,346.5	3,158.8	30%	75%	
ТҮЭМ-8	Дэд захирал, дэд дарга	1,474.0	1,621.0	1,718.0	2,233.4	3,006.5	30%	75%	
ТҮЭМ-7	Эрчимт, мэс засал, мэдээгүйжүүлэг, ЯТ, Гэмтэл, эх, хүүхэд, хавдрын эмч	1,404.0	1,544.0	1,637.0	2,128.1	2,864.8	30%	75%	
ТҮЭМ-6	Нарийн мэргэжлийн эмч	1,337.0	1,471.0	1,559.0	2,026.7	2,728.3	30%	75%	
ТҮЭМ-5	Ерөнхий мэргэжлийн эмч, даатгал, статистикч их эмч	1,273.0	1,400.0	1,484.0	1,929.2	2,597.0	30%	75%	
ТҮЭМ-4	Ахлах сувилагч, нарийн мэргэжлийн сувилагч	1,213.0	1,334.0	1,414.0	1,838.2	2,474.5	30%	75%	
ТҮЭМ-3	Ерөнхий мэргэжлийн сувилагч	1,155.0	1,271.0	1,347.0	1,751.1	2,357.3	30%	75%	
ТҮЭМ-2	Туслах, сувилагч, түргэн тусламжийн жолооч гм	1,100.0	1,210.0	1,283.0	1,667.9	2,245.3	30%	75%	
ТҮЭМ-1	Лабораторийн шил угаагч	1,000.0	1,100.0	1,166.0	1,515.8	2,040.5	30%	75%	
ТҮ-8	Ерөнхий нягтлан бодогч, эдийн засагч	1,114.0	1,337.0	1,417.0	1,842.1	2,479.8	30%	75%	
ТҮ-7	Нягтлан бодогч, хүний нөөц, инженер	1,053.0	1,264.0	1,340.0	1,742.0	2,345.0	30%	75%	
ТҮ-6	Нийгмийн ажилтан, биологич	1,003.0	1,204.0	1,276.0	1,658.8	2,233.0	30%	75%	
ТҮ-5	Техникч	912.0	1,094.0	1,160.0	1,508.0	2,030.0	30%	75%	
ТҮ-4	Нярав, нарийн бичиг	868.0	1,042.0	1,105.0	1,436.5	1,933.8	30%	75%	
ТҮ-3	Жолооч, цахилгаанчин, слесарь	827.0	992.0	1,052.0	1,367.6	1,841.0	30%	75%	
ТҮ-2	Асрагч	788.0	946.0	1,003.0	1,303.9	1,755.3	30%	75%	
ТҮ-1	Үйлчлэгч, жижүүр, угаагч	750.0	900.0	954.0	1,240.2	1,669.5	30%	75%	

Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын дундаж цалингийн өөрчлөлт

№	Албан тушаалын			Засгийн газрын 2026 оны 135 дүгээр тогтоол		
		зэрэглэл	тухайн зэрэглэлд хамаарах албан тушаал	2025 он	2026 он	Нэмэгдэх зөрүү
1	Удирдлага	ТҮЭМ-9	Эмнэлгийн Захирал, дарга	3,157.0	3,911.5	754.5
		ТҮЭМ-8	Дэд захирал, дэд дарга	2,723.4	3,374.3	650.9
2	Эмч	ТҮЭМ-7	Эрчимт, мэс засал, мэдээгүйжүүлэг, ЯТ, Гэмтэл, эх, хүүхэд, хавдрын эмч	3,136.0	3,885.5	749.5
		ТҮЭМ-6	Нарийн мэргэжлийн эмч	3,025.0	3,748.0	723.0
		ТҮЭМ-5	Ерөнхий мэргэжлийн эмч, даатгал, статистикч их эмч	2,262.0	2,802.6	540.6
3	Сувилагч	ТҮЭМ-4	Ахлах сувилагч, нарийн мэргэжлийн сувилагч	2,545.2	3,153.5	608.3
		ТҮЭМ-3	Ерөнхий мэргэжлийн сувилагч	2,167.0	2,684.9	517.9
4	Дэмжих	ТҮЭМ-2	Туслах, сувилагч, түргэн тусламжийн жолооч гм	1,888.0	2,339.2	451.2
		ТҮЭМ-1	Лабораторийн шил угаагч	1,742.0	2,158.3	416.3
ТҮЭМ-ийн ДУНДАЖ				2,516.2	3,117.5	601.4
5	Төрийн үйлчилгээний бусад	ТҮ-8	Ерөнхий нягтлан бодогч, эдийн засагч	2,210.5	2,738.8	528.3
		ТҮ-7	Нягтлан бодогч, хүний нөөц, инженер	2,090.4	2,590.0	499.6
		ТҮ-6	Нийгмийн ажилтан, биологич	1,990.6	2,466.3	475.7
		ТҮ-5	Техникч	1,809.6	2,242.1	432.5
		ТҮ-4	Нярав, нарийн бичиг	1,723.8	2,135.8	412.0
		ТҮ-3	Жолооч, цахилгаанчин, слесарь	1,641.1	2,033.3	392.2
		ТҮ-2	Асрагч	1,564.7	1,938.6	374.0
		ТҮ-1	Үйлчлэгч, жижүүр, угаагч	1,488.2	1,843.9	355.7
ТҮ-ийн ДУНДАЖ				1,814.9	2,248.6	433.8

/Энэхүү дундаж цалин хөлсний хэмжээ нь салбарын бүх албан хаагчдын цалинг шууд төлөөлөхгүй бөгөөд ажилласан жил, албан тушаал, нийслэл орон нутагт ажиллаж буй байршил, зэрэг дэв, илүү цагаас хамаарч өөр байна./

Асуулт 1.3. Эрүүл мэндийн салбарын төрийн захиргааны албан хаагчийн цалингийн нэмэгдлийн талаарх бодлого:

Хариулт:

Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбогдуулан төрийн захиргааны болон мэргэжлийн бусад чиг үүргийн ажилтнуудын цалин хөлс, зэрэглэлийг дүйцүүлэн нэмэгдүүлэх чиглэлээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлж байна.

1.Орон нутгийн эрүүл мэндийн газруудад ажиллаж буй төрийн захиргааны зэрэглэлийн албан хаагчдын үндсэн цалин нэмэгдээгүй байгаа нь хүний нөөцийн дутагдал үүсгэх эрсдэлтэй байгаа тул Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэлийг 2 зэрэглэлээр нэмэгдүүлэх саналыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2025-2026 онуудад удаа дараа хүргүүлэн ажиллаж байна.

2. Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулж, эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, лабораторийн чиглэлийн албан тушаалуудыг ТҮМ-9-өөс ТҮМ-5 зэрэглэлд дүйцүүлэн нэмж тусгах зохицуулалтыг хийж байна. Түүнчлэн эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний жагсаалтад “Эмнэлгийн физикч” (ТҮЭМ-7), “Туяа эмчилгээний техникч” (ТҮЭМ-5) болон Зоонозын өвчин судлалын салбарын нарийн мэргэжлийн албан тушаалуудыг шинээр нэмж, зэрэглэлийг нь тогтоох саналыг боловсруулан хүргүүлээд байна.

Асуулт 1.4. Цалингийн нэмэгдлийг санхүүжүүлэх эх үүсвэрийн талаарх мэдээлэл (улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сан, бусад эх үүсвэр):

Хариулт:

Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын цалин хөлсийг үе шаттай нэмэгдүүлж Засгийн газрын 2026 оны 135 дугаар тогтоолыг хэрэгжүүлж эхэлсэн үеийн тооцооллоор 2026 онд нийт 422.9 тэрбум төгрөг нэмэлтээр шаардлагатай болсон бөгөөд УИХ-аар 2026 оны төсөвт нийт 191.0 тэрбум төгрөгийг нэмэгдүүлэн баталсан болно. Иймд батлагдсан төсвийн хүрээнд цалин нэмэгдүүлэх шийдвэрийг хэрэгжүүлэхээр салбарын төсөвт тодорхой зохицуулалт хийх шаардлага бий болсон. Тухайлбал,

- Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн сахилга батыг сайжруулах, шаардлагагүй гэрээ, тусламж, үйлчилгээг хязгаарлах
- Эрүүл мэндийн байгууллагуудын бүтцийг оновчтой болгох замаар чиг үүргийн давхардлыг арилгах, бүтээмжийг нэмэгдүүлж зардлын хэмнэлт хийх,
- Эмнэлгийн стандартыг шинэчлэх, зардал өсгөсөн аливаа шийдвэрүүдийг нэгтгэж үр ашгийг нэмэгдүүлэх,
- ЭМД-ын сонгон шалгаруулалт, гэрээлэлт, тусламж үйлчилгээний багц, хамтын төлбөр зэрэг өөрчлөлтүүдийг хэрэгжүүлж нөөцийн дахин хуваарилалт хийх,
- Бараа материалын нөөцийн үлдэгдлийг бүрэн дайчилж, шаардлагагүй худалдан авалтыг хязгаарлах, төсвийн үрэлгэн байдалд хяналт хийх зэрэг бодлого, зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Мөн Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны жилийн эцсийн өр төлбөрийн төлсөнтэй холбоотой 2026 оны төсөвт үүсэж буй хэмнэлтээр цалин нэмэгдүүлсэн шийдвэрт хуваарилж хэрэгжүүлэхээр судлан тооцож ажиллаж байна.

Эхний 4 сарын байдлаар салбарын цалингийн төсөвт үзүүлсэн нөлөө сар бүр 19.8 тэрбум төгрөг байсан бол 5 сарын 1-ээс эхлэн /нэмэгдэл царцаахгүйгээр/ сар бүр 27.5 тэрбум төгрөгийн төсвийн нөлөө бий болж төсөвт ачаалал нэмэгдэхээр байна.

Цалин нэмэх асуудлыг 2026 оны 1-4 дүгээр сард Засгийн газрын 2025 оны 224, 225 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2026 оны А/11 дүгээр тушаалаар, 2026 оны 5 дугаар сараас 8 дугаар сар хүртэл Засгийн газрын 2026 оны 135 дугаар тогтоолоор, цаашид үе шаттай нэмэгдүүлэх төлөвлөлтийн дагуу тус тус хэрэгжүүлэн ажиллахад салбарын төсөвт үзүүлэх нөлөөллийг дараах хүснэгтээр харууллаа.

№	Агуулга	Ажилтны тоо	Цалин нэмэгдэх нөлөө	2026 оны төсөвт батлагдсан	Дутагдах эх үүсвэр	Тайлбар
1	ЭМД-ын санд үзүүлэх нөлөө	34212	398.4	185.0	213.4	Төрийн өмчийн нийт 444 байгууллага, 226 ӨЭМТ гүйцэтгэлээр ЭМД-ын сангаас санхүүждэг.
2	ЭМС-ын багцын төсөвт үзүүлэх нөлөө	2509	24.5	6.0	18.5	Төрийн өмчийн нийт 53 байгууллага улсын төсвөөс шууд санхүүждэг.
	Нийт	36721	422.9	191.0	231.9	

Эх үүсвэр нэмж шаардах 231.9 тэрбум төгрөгийн ЭМД-ын санд үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар зохицуулалт хийж шийдвэрлэхээр ажиллаж байна.

- 2024 оны эцэст 318.6 тэрбум төгрөгт хүрсэн хуримтлагдсан өр төлбөрийг 2025 оны эцэст 198.4 тэрбум төгрөг болгон 116 тэрбум төгрөгөөр бууруулсан нь санд тодорхой хэмжээний нөөцийн хуваарилалт хийх боломжийг бий болгосон.
- Тусламж үйлчилгээний багцыг шинэчлэн оновчтой болгож, жилийн 46-61 тэрбум төгрөгийн хэмнэлт хийх боломжийг бүрдүүлж ЭМДҮЗ-ийн 4 дүгээр тогтоолыг шинэчлэн баталсан.

Дээрх зохицуулалтуудаас гарсан төсвийн хэмнэлтийг төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэхэд зарцуулахаар тооцоолж Анхан шатны тарифыг 30 хувиар нэмэгдүүлэн шийдвэрлэсэн бол эмнэлгийн тусламж, үйлчилгээний ОХБ-ийн суурь тарифыг 8 хувиар, орон нутгийн нэмэгдлийн индексийг 12-22 хувиар тус тус нэмэгдүүлэх зохицуулалтыг хийсэн.

Асуулт 1.5. Цаашид уг нэмэгдлийг тогтвортой хадгалах, санхүүгийн чадавх, дунд хугацааны төсвийн хүрээний бодлоготой уялдуулж байгаа талаар:

Хариулт:

Салбарын албан хаагчдын цалин, хөлсний нэмэгдлийг үе шаттай нэмэгдүүлж урт хугацаанд тогтвортой хангах зорилгоор 2026 онд гарсан шийдвэрийг 2027 онд хэрэгжүүлэхээр Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгуулахаар Эрүүл мэндийн сайдын 2026 оны 1/1221, 1/1222 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд саналыг хүргүүлсэн. Уг саналд улсын төсвийн санхүүжилтийг 822.2 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг 1,388.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх тооцоолол хийгдсэн.

2026 онд хэрэгжих цалингийн нэмэгдэл нь 2027 онд бүтэн жилийн хугацаагаар үргэлжлэх тул төсвийн нөлөөлөл огцом нэмэгдэх төлөвтэй бөгөөд 2026 оны төсөвт цалингийн нэмэгдлийн нөлөө 422.9 тэрбум төгрөг байсан бол 2027 онд 825.0 тэрбум төгрөгт хүрэх тооцоотой байна. Үүнээс гадна нийгмийн даатгалын шимтгэл, эм болон хангамжийн материалын үнийн өсөлт зэрэг хүчин зүйлсийг тооцож төсвийн хүрээнд тусгуулахаар санал хүргүүлсэн.

ХОЁР. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг 2027 онд Дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувьд хүргэх зорилтыг тусгасан. Энэхүү зорилт нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх, эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн бэрхшээлийг бууруулах, стратегийн ач холбогдолтой билээ. Дээрхээс үндэслэн эрүүл мэндийн салбарын төсвийг ДНБ-ий 5 хувьд хүргэх зорилтын хэрэгжилтийн чиглэлээр хийж буй ажлуудыг тоймлон боловсрууллаа.

Эрүүл мэндийн салбарын улсын санхүүжилт нь Эрүүл мэндийн сайдын багцын улсын төсвөөс хуваарилах санхүүжилт болон Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт гэсэн хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэж байна.

Эрүүл мэндийн сайдын багцын улсын төсвийн санхүүжилт нь одоогийн эрх зүйн орчны хүрээнд Эрүүл мэндийн яам болон эрүүл мэндийн яамны харьяанд үйл ажиллагааны байгууллагуудын урсгал зардал, хөрөнгө оруулалт, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, дархлаажуулалт, эрүүл мэндийн боловсон олгох, хүний нөөцийг чадавхжуулах гэх мэт үйл ажиллагаанд зарцуулагдаж байна.

Харин Эрүүл мэндийн даатгалын сан нь иргэдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилт, эмийн хөнгөлөлт, анхан шатны тусламж, үйлчилгээний санхүүжилтийг хариуцан үр дүнд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилтийн зарчмаар эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээний үндсэн дээр санхүүжилт олгодог тогтолцоотой.

Эрүүл мэндийн сайдын багцын төсөв 2024-2029 он /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024 гүйц	2025 гүйц	2026 төсөв	2027 төсөл	2028 төсөөлөл	2029 төсөөлөл
Нийт орлого	2,398.0	2,651.5	3,236.5	4,898.1	6,681.5	6,748.4
- Улсын төсөв	1,540.9	1,614.3	1,979.0	3,854.0	3,503.0	3,108.6
- ЭМД сангаас	850.8	1,025.7	1,248.5	1,032.5	3,166.9	3,628.1
- Өөрийн орлого	6.3	11.5	9.0	11.6	11.6	11.7
Нийт зарлага	2,407.6	2,589.8	2,948.6	5,587.8	7,067.6	7,138.2
- Урсгал зардал	2,207.4	2,491.9	2,724.9	4,973.1	6,756.6	6,824.1
- Хөрөнгө оруулалт	200.2	97.9	223.7	614.7	311.0	314.1

Эрүүл мэндийн сайдын багц болон Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт төсөв 2026 онд 2,948.6 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд энэ нь 2026 оны хүлээгдэж буй ДНБ-ны 2.9 хувьтай тэнцэхээр байна.

Олон улсын байгууллагуудаас зөвлөмж болгодог эрүүл мэндэд зарцуулах төсвийн хэмжээ болох ДНБ-ний 5-6 хувь, Засгийн газрын төсвийн 12 хувиас доошгүй байх тухай түвшинтэй харьцуулахад хангалтгүй хэвээр байна. Монгол Улстай ижил төстэй эдийн засгийн чадамжтай улсуудтай харьцуулахад Монгол Улсын эрүүл мэндийн салбарын санхүүжилт харьцангуй доогуур түвшинд байна.

Сонгож авсан улсуудын эрүүл мэндийн санхүүжилтийн зарим үзүүлэлтийн харьцуулалт

Улс	ЭМД шимтгэлийн хувь	Эрүүл мэндийн улсын зардлын ДНБ-нд эзлэх хувь
Монгол	4.0% (2+2)	2.9% (2026)
БНСУ	7.1%	9.7%
Япон	10.0%	11.5%
ХБНГУ	14.6%	12.7%
Франц	13.6%	12.1%
Чех	13.5%	9.7%
Тайланд	Холимог	4.4%
Филиппин	Холимог	5.5%
Вьетнам	4.5%	4.6%
Их Британи	Татварт суурилсан	10.0%
Австрали	Татварт суурилсан	9.6%
Сингапур	Татварт суурилсан	4.5%
ОУ байгууллагын зөвлөмж	—	6.0% ба түүнээс дээш

Эх сурвалж: OECD Health at a Glance 2024, ДЭМБ Global Health Expenditure Database 2024, OECD Stat 2024.

Эрүүл мэндийн салбарт зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг бүрдүүлэх нь хамгийн их тулгамдсан асуудал болж байгаа бөгөөд үеийн Засгийн газар, Эрүүл мэндийн яамны зүгээс энэ чиглэлээр ажиллаж, олон улсын туршлага, дэмжлэгтэйгээр хувилбар, тооцоо судалгааг боловсруулж ирсэн. Эрүүл мэндийн салбарын гол орлого болох албан журмын эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, улсын төсвөөс олгож буй санхүүжилт, эрүүл мэндийн татварын орлогыг нэмэгдүүлэх замаар хэрэглээг хумих, тодорхой санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх, зохих тусламж, үйлчилгээнд санхүүгийн дарамт учруулахгүйгээр хамтын төлбөрийн орлого бүрдүүлэх зэрэг чиглэлд ажлууд хийж байна.

Асуулт 2.1. Дээрх зорилтыг хэрэгжүүлэх эрх зүйн болон бодлогын баримт бичгийн уялдааны талаарх мэдээлэл (жишээлбэл: улсын төсөв, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, салбарын стратеги)

Хариулт:

Эрүүл мэндийн салбарын нийт төсвийг олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу ДНБ-ний 5 хувьд хүргэх зорилгоор УИХ болон Монгол Улсын Засгийн газраас үе шаттай ажлуудыг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж байгаа билээ.

- Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод эрүүл мэндийн үйлчилгээнд даатгалын, улсын төсвийн болон хувь хүний санхүүжилтийн зохистой харьцааг бий болгох зорилт тусгагдсан;
- Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилт тусгагдсан;
- Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг 2027 онд ДНБ-ний 5 хувьд хүргэх зорилт тусгагдсан зэрэг байна.

Эдгээр тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах иргэдийн болон албан бус салбарын даатгуулагчдын төлөх шимтгэлийн хувь хэмжээг 2025-2028 он хүртэл үе шаттай 6 хувь болгож өсгөх зорилт батлагдсан болно.

Эдгээр баримт бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 2026-2028 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/530 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж эхэлсэн.

Мөн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/428 дугаар тушаалаар баталж, одоогийн хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг хэрэгжүүлж байна.

Асуулт 2.2. 2026-2027 онд эрүүл мэндийн салбарын төсвийн ДНБ-д эзлэх хувь бодитоор хэдэн хувь байгаа, цаашид 5 хувьд хүргэх үе шат, тооцоо, төлөвлөлтийн талаар:

Хариулт:

Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуулиар Эрүүл мэндийн сайдын багцын улсын төсвийн санхүүжилтийг 1,988.0 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулиар сангийн зардлыг 2,458.8 тэрбум төгрөгөөр тус тус баталсан. Салбарын нийт төсвөөр /ЭМДС-нд төвлөрүүлдэг 1,498.2 тэрбум татаасыг цэвэрлэсэн дүнгээр/ 2,948.6 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд ДНБ-нд эзлэх хувиар 2.9 хувийг эзэлж байна.

2027 оны төсвийн хүрээний мэдэгдэлд эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг ДНБ-ний 5 хувьд хүргэх тооцооллыг хийж холбогдох яамдууд хүргүүлсэн. Уг саналд 2027 оны төсвөөр Эрүүл мэндийн сайдын багцын улсын төсвийн санхүүжилтийг 822.2 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг 1,388.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх буюу нийт 2,210.4 тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэр шаардлагатай гэж тооцоолж саналыг тусгасан.

2027 оны төсвийн хүрээний мэдэгдлийн саналд нэмэгдүүлэхээр тусгасан арга хэмжээ /тэрбум төгрөг/

Төсвийн ерөнхий ангилал	2027 онд нэмэлт шаардлагатай	Эрх зүйн үндэс /товч/
1. Урсгал зардал /ЭМС-ын багц/	210.0	Цалингийн өсөлт 58.8, эмийн хууль 3.7, мэдээллийн систем 3.6, эрт илрүүлэг 55.9, бусад
2. Эрүүл мэндийн даатгалын сан	1,388.2	Тусламж, үйлчилгээ 1,351.4 (цалингийн нөлөө), хөнгөлөлттэй эм 35.7
3. Хөрөнгө оруулалт	614.7	Барилга байгууламж 398.3, их засвар 144.4, бусад 72.0
НИЙТ	2,212.9	Үүнээс 822.2 тэрбум УТ, 1,388.2 тэрбум ЭМД сан

Асуулт 2.3. Санхүүжилтийг нэмэгдүүлэх эх үүсвэр, бүтэц (татварын орлого, даатгалын сан, гадаад зээл тусламж, гэх мэт)-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

Хариулт:

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг зорилтот түвшинд хүрэх гол асуудал нь эх үүсвэрийг нэмэгдүүлэх явдал бөгөөд Эрүүл мэндийн яамнаас дараах эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлийн олон улсад байдаг жишгийн дагуу ажлуудыг хэрэгжүүлж, холбогдох хуулиудад өөрчлөлт оруулахад ажиллаж байна.

Эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүний онцгой албан татварыг олон улсын жишигт хүргэх асуудал.

Монгол Улсад 2025 оны байдлаар архи, согтууруулах ундаанаас 489.5 тэрбум төгрөг, тамхинаас 300.7 тэрбум төгрөг, нийт 790.2 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрсөн. Тамхины татварын хувь хэмжээ ДЭМБ-ын зөвлөмжийн 70 хувиас 40 нэгж хувиар, архины татварын хувь хэмжээ ДЭМБ-ын зөвлөмжийн 60 хувиас 25 нэгж хувиар тус тус доогуур байгаа тул татварын түвшинг олон улсын жишигт хүргэснээр жилд нэмэлт 271.0 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлэх боломжтой гэж тооцоолсон.

Архи, тамхины онцгой албан татварыг олон улсын жишигт хүргэх боломжийн тооцоо

Бүтээгдэхүүн	Одоогийн нийт татварын орлого, тэрбум төгрөг	Одоогийн татварын түвшин	ДЭМБ-ын зөвлөмжийн түвшин	Татварыг нэмэгдүүлэх орон зай	Нэмэлт орлогын боломж, тэрбум төгрөг
Тамхи	300.7	30%	70%	+40	75.2
Архи, согтууруулах ундаа	489.5	35%	60%	+25	195.8
НИЙТ	790.2	—	—	—	271.0

Эх сурвалж: Сангийн яам, Татварын ерөнхий газар 2026 он, ДЭМБ Global Health Expenditure Database 2024.

Олон улсын туршлагаас үзэхэд Филиппин Улсад тамхины нэмэгдсэн татварын орлогын 85 хувь, архины нэмэгдсэн татварын орлогын 100 хувийг үндэсний эрүүл мэндийн даатгалд чиглүүлдэг; Франц, Япон, Тайвань зэрэг улсад эдгээр татварын тодорхой хувийг нийгмийн эрүүл мэндийн даатгалд ашигладаг туршлагатай. Монгол Улсад одоогоор тамхины онцгой албан татварын 2 хувь, архины онцгой албан татварын 1 хувийг Эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлдэг бөгөөд энэ хувь хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх, эсвэл шинээр нэмэгдэх татварын орлогын тодорхой хувийг шууд Эрүүл мэндийн даатгалын санд чиглүүлэх асуудлыг судалж байна.

Чихэрлэг ундааны татварыг шинээр нэвтрүүлэх асуудал.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас чихэрлэг ундааны жижиглэн худалдааны үнийн дор хаяж 20 хувийг чихрийн агууламжид суурилсан татвараар ногдуулахыг зөвлөдөг. Португал Улсад тус татварын орлогыг Үндэсний эрүүл мэндийн албанд, Филиппинд эрүүл мэнд, хоол тэжээл, нийгмийн хамгааллын арга хэмжээнд тус тус ашигладаг. Чихрийн шижин, таргалалт, зүрх судасны өвчний дарамтыг бууруулах ач холбогдолтой бөгөөд 2027 оноос тус татвар хэрэгжүүлэх бэлтгэл хийгдэж байна. Эрүүл мэндийн яамны зүгээс холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах байдлаар ажиллаж байна. Монгол Улсад тус татварын тогтолцоог бүрэн хэрэгжүүлснээр хэрэглээг хязгаарлах, ирээдүйд үүсэх олон төрлийн өвчлөлөөс сэргийлэх боломжтой бөгөөд хажуугаар нь урьдчилсан тооцоогоор тус татвараас жилд 50-80 тэрбум төгрөгийн нэмэлт орлого бүрдүүлэх боломжтой гэж үзэж байна.

Электрон тамхины эрх зүйн зохицуулалт, татвар.

Электрон тамхи /e-cigarette, vape/-ны хэрэглээ ялангуяа залуу үе, өсвөр насныхны дунд эрчимтэй тархаж байгаа боловч Монгол Улсад тус бүтээгдэхүүний өвөрмөц эрх зүйн зохицуулалт, татварын тогтолцоо одоогоор бүрдээгүй байна. ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийн /FCTC/ хүрээнд олон улсад электрон тамхины эх үүсвэр, борлуулалт, зар сурталчилгаа, татварын зохицуулалтыг улам бүр чанд болгож байна. Тамхины хяналтын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд цугларсан орлогын тодорхой хэсгийг эрүүл мэндийн салбарт зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлж чадвал салбарын төсвийг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.

Албан секторын ЭМД-ын шимтгэлийн хувь хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх.

Монгол Улсын албан секторын ЭМД-ын нийт шимтгэлийн хувь хэмжээ нь ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь буюу нийт цалингийн 4 хувь байгаа бусад улс орнуудын жишгээс 2-3 дахин бага түвшинд байна.

Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолд тусгасан зорилтын дагуу шимтгэлийн хувь хэмжээг 2027 оноос 2028 он хүртэл үе шаттай нэмэгдүүлж нийт 6 хувьд (ажил олгогч 3 хувь + ажилтан 3 хувь) хүргэх ажлыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яаманд санал хүргүүлж байгаа бөгөөд үүнд шийдвэр гаргах түвшинд УИХ болон Засгийн газрын дэмжлэг чухал байна. Шимтгэлийг шууд огцом нэмэгдүүлэх нь улсын эдийн засаг бусад салбарын зарим асуудалд эрсдэлтэй тул үе шаттай бага хувиар нэмэгдүүлж зорилтод түвшинд хүргэх нь чухал юм. 2025 оны шимтгэлийн орлогын суурь дээр тооцоход бүтэн өөрчлөлтөөр жилийн 480-520 тэрбум төгрөгийн нэмэлт орлогыг санд төвлөрүүлэх боломжтой.

Төр шимтгэлийг нь хариуцах иргэдийн шимтгэлийг нэмэгдүүлэх.

Сүүлийн 5 жилийн дунджаар төрөөс шимтгэлийг нь хариуцах иргэдийн шимтгэлийн орлого нь Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлогын 14 орчим хувийг бүрдүүлж байгаа боловч тус бүлгийн иргэд тусламж, үйлчилгээний зардлын 76 орчим хувийг ашиглаж байна. Эв санааны зарчимд тулгуурласан эрүүл мэндийн даатгалын тогтолцоо хэдий ч төр шимтгэлийг нь хариуцах иргэдийн тоо хэт өндөр, төрөөс олгож буй шимтгэлийн мөнгөн дүн хангалттай биш байгаа учраас Эрүүл мэндийн яамнаас тус бүлгийн нэг хүнд ногдох шимтгэлийн хувь хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон одоогийн 2 хувиас 2027 оноос үе шаттай 3 хувьд, 2029 он гэхэд 4 хувьд хүргэх саналыг боловсруулсан. Энэ өсөлт нь 2025 оны суурь дээр тооцвол жилд 175-260 тэрбум төгрөгийн нэмэлт орлогыг санд төвлөрүүлэх боломжтой байна.

Шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг иргэдийн хамралт, тогтмол төлөлтийг нэмэгдүүлэх.

2025 оны байдлаар хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид, оюутан, гадаадад оршин суугч иргэдийн шимтгэлийн орлого 44.1 тэрбум төгрөг буюу сангийн нийт орлогын 1.9 хувийг эзэлж байгаа нь маш бага үзүүлэлт байна. Ижил төстэй эрүүл мэндийн даатгалын тогтолцооны улсууд болох БНСУ, Казахстан зэрэг улсуудтай Монгол Улсыг харьцуулбал эдгээр улсуудад албан бус салбарын даатгуулагчид нь нийт даатгуулагчдад эзлэх хувь нь 20-30 хувьтай байгаа боловч төвлөрүүлж буй орлого нь Монгол Улс Казакстанаас 2 дахин, БНСУ-аас 5 дахин бага байна.

Тус иргэдийн хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн яам нь хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн шимтгэлийг зөвхөн цалингийн орлогоос бус бусад орлогоос нэмэгдүүлэх боломжийг олон улсад болон адил төстэй хүн ам, эдийн засгийн үзүүлэлт ойролцоо орны туршлагыг судлах байдлаар тогтоох, нэвтрүүлэх ажлыг хийхээр төлөвлөж байна. Энэхүү ажлыг эрчимжүүлж хэрэгжүүлснээр ЭМД-ын санд тодорхой эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.

Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрийг чиглүүлэх.

Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрийг хүний нөөц, цахим шилжилт, өндөр өртөгтэй тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, хүний нөөцийг сургах, хөрөнгө оруулалтын шинж чанартай зардлуудад чиглүүлэх стратегийг баримталж байна. Энэ чиглэлээр ялангуяа хөрөнгө оруулалт, чадавх бэхжүүлэх чиглэлд гадаадын зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэхэд анхаарч 2026 оны төсөвт Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зээлийн хөтөлбөрийг боловсруулж төсвийг нь батлуулсан бөгөөд зээлийн хэлэлцээрийн төгсгөлийн шатанд явж байна. Энэхүү төслүүд нь амжилттай хэрэгжсэнээр эрүүл мэндийн салбарын төсвийн хэмжээнд тодорхой үр дүнгүүд өгч бодит үр дүн нь салбарт гарна.

Асуулт 2.4. Зорилтыг хангах хүрээнд хэрэгжүүлэх бодлогын шинэчлэл, бүтцийн өөрчлөлтийн мэдээлэл (үр ашиг, зардлын хяналт, худалдан авалт, анхан шатны тусламж үйлчилгээний санхүүжилт):

Хариулт:

Санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тус нэмэгдэж буй санхүүжилт нь үр ашигтай зарцуулагдах нөхцөлийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай. Энэ хүрээнд дараах бодлогын шинэчлэл, бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлж байна.

2021 оноос эрүүл мэндийн улсын төсвийг Эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэн стратегийн худалдан авалтын (нэг худалдан авагчийн) тогтолцоонд шилжсэн нь иргэн, даатгуулагчийг эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах, тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах, эрүүл мэндийн байгууллагуудыг

гүйцэтгэлээр санхүүжүүлэх зэрэг чухал эерэг үр дүнг авчирсан. Гэвч энэ нь нэхэмжлэлийн тоо хэмжээний огцом өсөлт, эрүүл мэндийн байгууллагуудын зардлын тэлэлт зэрэг сорилтыг үүсгэсэн тул сангийн зардлын хяналтын механизмыг бэхжүүлэх шаардлагатай болсон.

2025 онд хэрэгжүүлсэн зардлын хяналтын цогц арга хэмжээний үр дүнд сангийн санхүүгийн төлөв байдалд эерэг өөрчлөлт гарсан бөгөөд сангийн хуримтлагдсан өр төлбөр буурсан. Тодруулбал:

- тусламж, үйлчилгээг цочмог, төлөвлөгөөт, архаг гэсэн гурван тэргүүлэх ангилалд хуваан санхүүжүүлэх зохицуулалт нэвтэрсэн;
- зарим архаг тусламж, үйлчилгээг тодорхой түвшинд хязгаарлах, хувийн хэвшлээс зөвхөн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг худалдан авах, эрт илрүүлгийн зарим хөтөлбөрийг түр зогсоох арга хэмжээ авсан;
- ОХБ-ийн эмийн хэвтүүлэн эмчлэх 38, мэс заслын 33 буюу нийт 70 гаруй ОХБ-ийн хүрээнд 11,000 өвчний түүхийг түүвэрлэн шинжлээд хасах, нэгтгэх, өдрийн мэс засал руу шилжүүлэх боломжтой тусламж, үйлчилгээний жагсаалт боловсруулсан бөгөөд жилийн нийт хэмнэлт 46-61 тэрбум төгрөгт хүрэх боломжтой гэж тооцоологдсон.

Анхан шатны тусламж, үйлчилгээний санхүүжилт 2021 онд 213.8 тэрбум төгрөг, 2022 онд 316.7 тэрбум төгрөг, 2023 онд 346.9 тэрбум төгрөг, 2024 онд 425.0 тэрбум төгрөг, 2025 онд 513.9 тэрбум төгрөгт хүрч үе шаттай нэмэгдсэн бол 2026 онд 608.3 тэрбум төгрөгт хүргэхээр баталсан. Энэ нь 2021 онтой харьцуулахад 2026 онд 2.85 дахин өссөн үзүүлэлт юм.

Цаашид анхан шатны тусламжийн санхүүжилтийг нийт зардлын 25-30 хувьд хүргэх зорилт тавин ажиллаж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2026 оны 01 дүгээр тогтоолоор нэг иргэний суурь тарифыг 35.5 мянган төгрөгөөс 46.2 мянган төгрөгт хүргэж 30 хувиар нэмэгдүүлсэн нь анхан шатны эмч, ажилтнуудын цалин хөлсний нэмэгдлийг тарифын өсөлтийн бодлогоор хангах боломжийг бий болгож байна.

Түүнчлэн 2026 оны 4 дүгээр сарын 15-нд Эрүүл мэндийн салбарт авах зарим арга хэмжээний талаар Засгийн газрын 134 дүгээр тогтоол гаргасан бөгөөд тус тогтоолын хүрээнд салбарын үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс анхан болон лавлагаа шатлалын зохион байгуулалтыг өөрчлөх, эмийн төвлөрсөн болон нэг эх үүсвэрийн худалдан авалтын зохицуулалтыг сайжруулж үр ашгийг нэмэгдүүлэх, цалин урамшууллын тогтсон тогтолцооноос үр дүн, бүтээмжид суурилсан уян хатан цалингийн тогтолцоонд шилжих, эмнэлгийн дэмжих үйлчилгээнүүдийг нэгтгэх, төр хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр үр ашигтайгаар зохион байгуулах, салбарын цахимжилтыг шийдвэрлэж, шаардлагагүй мэдээлэл, тайлангийн тогтолцоог халах байдлаар ажилчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зэргээр цогц арга хэмжээ авах шийдвэр гаргаж, түүнийг хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Асуулт 2.5. Хэрэв зорилтот түвшинд хүрэхэд эрсдэл саад бэрхшээл байгаа бол түүнийг даван туулах бодлогын шийдлийн талаар:

Хариулт:

Эдийн засгийн гадаад хүчин зүйлсийн нөлөөллийн хүрээнд салбарын төсвийн тогтвортой байдал алдагдах, ЭМД-ын сангийн орлого тасрах, улсын төсвийн орлого тасалдаж, тогтсон хугацаанд санхүүжилт төвлөрөхгүй байх, инфляц, ханшийн өөрчлөлт, түүхий эдийн үнийн өөрчлөлт зэрэг нь бодит эрсдэл байгаа бөгөөд салбарын зүгээс төсвийн сахилга батыг сайтар хангаж, аль болох шинэ арга хэмжээг төлөвлөхгүй байх, одоогийн санхүүжилтийг оновчтой хуваарилахад

анхаарч хэмнэлтийн горимоор ажиллаж байна. Түүнчлэн улс төрийн нөлөөлөл, гэнэтийн шийдвэрийн улмаас зардал тэлсэн аливаа шийдвэрээс урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллаж байна.